

НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНД
БИОЛОГИЙН ХИЧЭЭЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН
СЭТГЭЛ ХАНАМЖИЙН СУДАЛГАА

Мөнхжаргал Э., Хишигжаргал Г.
“Ач” Анагаах ухааны их сургууль
e-mail: munkhjargal@ach.edu.mn

Abstract

**STUDENT'S SATISFACTION SURVEY WITH IMPLEMENTATION
OF THE CURRICULUM OF “BIOLOGY”**

Munkhjargal E., Khishigjargal G.
“Ach” Medical University
e-mail: munkhjargal@ach.edu.mn

Background

The purpose of this study is to investigate students' satisfaction whose were studying in the academic years 2020-2021, 2021 - 2022 with the biology curriculum at "Ach" Medical University, to evaluate the effectiveness of the teaching method, and to improve the planning and execution of future teaching and learning activities based on the students' perceptions.

Introduction

One of the ways to evaluate the quality of services of higher education institutions is the student satisfaction survey. The satisfaction of any customer with the service that they receive depends on many factors. We conducted a survey on the satisfaction of students who are the main users of the Biology curriculum at Ach Medical University, and considered that it is necessary to pay further attention to the fact that the results taking and the requirements.

Purpose

The purpose of this study is to take a survey of the satisfaction of the students of the biology curriculum of "Ach" Medical University based on the perceptions of the students, give an evaluation and conclusion about the teaching activities and improve the teaching quality and methodology.

Materials and Methods

This research is based on the HEdPERF model Beaumont (2012) who has developed a model for evaluating the quality of higher education with 6 factors, each factor having 4 questions and 1-10 points. F of these factors were used in this research [12]. It includes:

1. Training-Lecture Quality, Seminar/Laboratory Quality, Teacher's Teaching Methodology, Importance of Course Content
2. Teacher-Professional knowledge and experience: Ability to support and help students, Recognize the needs of the students, Ability to attract student's attention in training, Communication skills
3. Organization and materiality of study - Organization, Management, Flexibility of the training, Quality, and Availability of training materials and equipment

In the academic year 2020-2021 and 2021-2022, students who studied biology were asked to evaluate the performance of the "Biology" curriculum by answering 30 questions with 3 groups of questions using Google form, and answering one of the points 1, 2, 3, 4, 5 for each question and collected the research material by clarifying.

General information of the research participants

147 first-year students in "Ach" Medical University aged 17-20, 86.4% female and 13.6% male, or 29.4% of all students, participated in the survey.

Result

Teaching process of biology course

The participants of the research who studied the biology course through combined online and classroom learning answered that the lecture course was conducted that explains the phenomenon broadly in a scientific unity. They answered that the method of lecturing is appropriate for explaining cases, repeating topics, clarifying interrelationships, the content and quantity of independent work, and practical importance if the tasks are completed.

Evaluation methodology of the teaching

The participants said that the lessons are taught clearly, with real-life examples, communication between teacher and students is proper, independent work is checked promptly, the results reporting is done on time and the evaluation is as realistic.

When the teacher asks for corrections during class in the future:

The students said that if the teacher has more conversations with them, if the teacher speaks louder while taking classes, and some answered that there is nothing to correct.

Biology curriculum evaluation

When asked about the environment for implementing the Biology curriculum and the availability of teaching materials, the students said it is moderate. In response to the question of describing the advantage and disadvantages of the Biology curriculum:

- The knowledge and skills of the teacher, as well as the opportunity to learn from other programs are an advantage
- Classrooms, equipment, and e-learning were evaluated as weaknesses.

Conclusion:

1. According to the satisfaction survey results obtained from 147 students who are representatives of the students who studied Biology in the 1st year of 2021 and 2022 at "Ach" Medical University, it was concluded that the teaching process of biology is 84.8 percent or good.
2. In order to further improve the course's quality and results, and also each student's practice, it was determined that some changes to the ratio of the content of the lectures and seminars, in addition to attending practice classes regularly in the classroom and with mutual discussion, are required.

Keywords: satisfaction survey, curriculum, class of biology, online learning, combined online and classroom learning

Pp.12-23, Figures 15, References 16

Удиртгал

Дээд боловсролын байгууллагын сургалтын чанарыг үнэлэх нэг арга нь суралцагчийн сэтгэл ханамжийн судалгаа юм [5].

“Ач” АУИС-д суралцагчдын оюутны сэтгэл ханамжийн судалгааг сүүлийн 10-аад жил тасралтгүй явуулж байгаа бөгөөд хичээлийн жил бүр 2 удаа авч багшийн сургалтын ажлын чанар, аттестатчиллын нэгэн үзүүлэлт болгон тооцож ирсэн [1].

Сургалтын үйл ажиллагаанд оролцогч талуудын олон талт үнэлгээ хийх, гарсан үр

дүн нь сургалтын үр дүнд эергээр нөлөөлдөг хүчин зүйл байлгах тал дээр цаашид анхаарах шаардлагатай гэж манай судалгааны баг үзэж, Биологийн хичээлийн хөтөлбөрөөр суралцсан бакалаврын оюутнуудын сэтгэл ханамжийн судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, хөтөлбөрт өгч байгаа үнэлгээний түвшинг тодорхойлж, оюутны суралцахад тулгарч байгаа хүндрэлтэй асуудлуудыг судлан тогтоож, сургалтын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэхэд оюутнуудынхаа сонирхол шаардлагыг харгалзан үзэж сайжруулах асуудлыг авч үзэж байна.

Зорилго

“Ач” АУИС-ийн Биологийн хичээлийн хөтөлбөрийг судлаж буй оюутан суралцагчдын сэтгэл ханамжийн судалгааг явуулж, сургах үйл ажиллагааны талаар оюутнуудын бодол саналд тулгуурлан судлаж үнэлэлт, дүгнэлтийг өгч цаашид сургалтын ажлын зохион байгуулалт, хөтөлбөрийн агуулга, арга зүй, технологи, сургалт явуулах орчин нөхцлийг сайжруулахад оршино.

Материал, арга зүй

Энэхүү судалгааг 2020-2021, 2021-2022 оны хичээлийн жилд биологи хичээл судласан оюутнуудаас **Google form, Excel програм ашиглан санал асуулгын аргаар** Хичээл сургалтын үйл явц, Багшийн сургах зүй, арга барил, Хөтөлбөрийн хэрэгжилтэнд үнэлгээ өгөх гэсэн агуулгаар 3 бүлэг асуулт бүхий хаалттай 35 асуумжаар, асуулт бүрт 1, 2, 3, 4, 5 гэсэн онооны аль нэгийг сонгон (5 нь тухайн асуулт буюу нотолгооны хамгийн эерэг үнэлгээ, харин 1 нь хамгийн сөрөг буюу хангалтгүй үнэлгээ өгөх) хариулж Биологийн хичээлийн **хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлүүлэх** байдлаар оюутны сэтгэл ханамжийн тодруулах замаар судалгааны материалаа цуглуулсан.

“Ач” АУИС-ийн 5 бүрэлдэхүүн/салбар сургуулийн (Анагаах, Нүүр ам судлал, Уламжлалт анагаах ухаан, Сувилал, Нийгмийн эрүүл мэнд) түвшин нэгдүгээр дамжааны 147 оюутнаас санамсаргүй байдлаар түүвэрлэн жилд 2 удаа цахим хэлбэрээр судалгааг авсан.

А. Суралцагчийн ерөнхий мэдээлэлд хүйс, нас, сургууль хөтөлбөрийн түвшин гэсэн сонгох байдлаар мэдээллээ бичнэ.

Б. Сургалтын чанарын үзүүлэлт нь сургалт,

багш, сургалтын зохион байгуулалт, материаллаг байдал гэсэн хэсгээр хэсэг тус бүрт сэтгэл ханамжийн асуумжтай. Асуумж бүр нь Ликертийн хэмжүүр ёсоор 5 шкалаар 1-5 оноогоор үнэлсэн.

Энэ цуглуулсан материалууддаа статистикийн энгийн аргаар нээлттэй санал асуумжийг хамгийн чухал болон чухал биш тус бүр үзүүлэлтийг бичиж тайлбарлан задлан шинжилж цаашдын хөтөлбөрийн хэрэгжилтэд анхаарах, сургах үйл ажиллагааны талаар үнэлэлт, дүгнэлтийг өгч сургалтын ажлын зохион байгуулалт, **хөтөлбөрийн агуулга, арга зүй, технологи, хэрэгжүүлэх орчинг сайжруулахад анхаарах** бодит байдлыг илэрхийлэхийг эрмэлзсэн.

Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

Судалгаанд “Ач” АУИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилд 100 хувь цахим, 2021-2022 оны хичээлийн жилд 50:50 хувь цахим-танхимын сургалтаар суралцсан нэгдүгээр дамжааны 17-20 насны 86,4% нь эмэгтэй, 13,6% нь эрэгтэй 147 оюутан буюу нийт оюутнуудын 29,4 хувь нь хамрагдсан.

Үр дүн

1. Биологийн хичээлийн сургалтын үйл явц

1.1. Хичээлийг явуулж буй арга барил

2021-2022 оны хичээлийн жилд Биологийн хичээлийг 50 хувь цахим - 50 хувь танхимын сургалтаар судалсан судалгаанд оролцогчид лекцийн хичээлийг 47.2 хувь нь юмс үзэгдлийг өргөн хүрээгээр тайлбарласан байдлаар, 33.1 хувь нь шинжлэх ухааны нэгдмэл байдлаар, 26 хувь нь тулгуур зүй тогтлыг бий болгох байдлаар хичээлийг явуулдаг гэж хариулсан байна (Зураг 1).




Figure 1. Teaching theoretical knowledge through biology lectures

Тус хичээлийн жилд лекцийн хичээлийг 25.8 хувь нь жишээ баримтыг тайлбарласан, **39.2 хувь нь сэдвийг дахин давтаж харилцан**

холбоо хамаарлыг тодоройлсон, 35 хувь нь агуулгыг нэгтгэн дүгнэсэн байдлаар таниулсан байна (Зураг 2).




Figure 2. Teaching Biology method

Семинарын хичээлийн явц

2021-2022 оны хичээлийн жилд Биологи хичээлийг Цахим-Танхимаар судалсан судалгаанд оролцогчид семинарын хичээлийг

55,3 хувь нь мэдлэг, чадварыг хамтад нь олгодог, 33.3 хувь нь агуулгыг харьцуулж дүгнэдэг гэж хариулсан байна (Зураг 3).




Figure 3. Delivering knowledge and skills during seminar

Бие даалтын явц

2021-2022 оны хичээлийн жилд цахим болон танхим хослуулан ороход бие даан гүйцэтгэж буй ажлын агуулга, тоо хэмжээ тохирч буй эсэхийг асуухад нийт оролцогч оюутны 39.2 хувь нь маш

тохиромжтой, 35.2 хувь нь тохиромжтой, 18.4 хувь нь дунд зэрэг тохиромжтой, биелүүлбэл зохих даалгавар 36 хувь нь маш үр дүнтэй, 38.4 хувь нь үр дүнтэй гэж хариулсан (Зураг 4).




Figure 4. Content quantity and results of Self Independent Work

1.2. Хичээлийн уялдаа холбоо

2020-2021 оны Биологийн хичээлийн лекц болон семинарын хичээлийн дараалал болон сэдэвчилсэн хичээл хоорондын уялдаа нь 90.9 хувь нь өмнөх хичээлтэйгээ уялддаг гэсэн байхад 2021-2022 оны Биологийн хичээлийн

лекц болон семинарын хичээлийн дараалал болон сэдэвчилсэн хичээл хоорондын уялдаа нь 73.2 хувь нь өмнөх хичээлтэйгээ уялддаг, 23.9 хувь нь дараагийн хичээлтэйгээ уялдаа холбоотой байдаг гэж дүгнэжээ (Зураг 5).




Figure 5. Lesson content relationships

1.3. Сурах бичгийн хүрэлцээ хангамж

2021-2022 оны хичээлийн жилд Биологийн хичээлд ашиглаж байсан үндсэн сурах бичгийн

хүрэлцээ хангамж 39.6 хувь нь сайн, 42.7 хувь нь маш сайн гэж дүгнэсэн (Зураг 6).





Figure 6. Supply of book and manuals

“Биологи” хичээлийн мэдлэгийг 49.2 хувь нь шууд ашиглахад зарим нэг асуудал тулгардаг

учраас амьдрал практикт 21.8 хувь нь хэрэглэж үзээгүй гэж хариулжээ (Зураг 7).



Зураг 7. Practical use of Biology course

2. Багшийн сургах зүйн үнэлгээ

Судалгаанд оролцогчдын 78 хувь нь багшийг хичээлдээ сайн бэлтгэлтэй, 68 хувь нь хичээлийн сэдвээ амьдралын бодит жишээгээр баяжуулсан, 79.2 хувь нь хичээл ойлгомжтой, 60 хувь нь багш асуултанд төвөгшөөдөггүй хариулдаг, 85.2 хувь нь багш цагийг үр бүтээлтэй ашигладаг, 79 хувь нь оюутантай зөв боловсон

харьцдаг, 68.5 хувь нь хүссэн үед зөвөлгөө авдаг, 86.3 хувь нь даалгавар бие даах ажлыг шуурхай шалгаж дүнг эргэж мэдэгддэг, багшийн үнэлгээ 79.8 хувь нь бодитой, 87.2 хувь нь багшийг сайн гэсэн үнэлгээг тус тус өгсөн байна.

Мөн багш оюутныг хичээлд идэвхитэй, сурах сонирхлыг төрүүлдэг эсэхэд 64.8 хувь нь эерэг буюу сайн гэсэн үнэлгээ өгчээ (Зураг 8).




Figure 8. Motivation to learn Biology

Биологийн хичээлээр оюутны санал бодлоо зөв илэрхийлэх, багаар ажиллах, аливаа зүйлд шүүмжлэлтэй, бүтээлч хандах чадвар төлөвшүүлэхэд анхаардаг эсэхийг асуухад 34.7

хувь нь сайн, 25.8 хувь нь маш сайн анхаардаг нийт 60.5 хувь нь хичээлийн явцад оюутнаа сурахад тусалдаг гэж хариулжээ (Зураг 9).




Figure 9. Obtained skills through the biology lesson

Цаашид багш хичээл заахдаа анхаарах зүйлсийг асуухад:

Цахим хэлбэрээр хичээл орж байхад оюутнуудын 31.8 хувь нь лекц семинарын хичээлийг орохдоо оюутнуудтайгаа илүү их харилцан ярилцаж орвол илүү ойлгомжтой, 13.6 хувь нь засах зүйл байхгүй, 9.1 хувь нь хичээл

орж байхдаа чанга ярих хэрэгтэй, үлдсэн зарим хэсэг нь лекц уншихад хэт их, хичээлийг урьдчилан явуулах нь зохимжгүй байна гэж тус тус хариулжээ (Зураг 10).




Figure 10. Further considerations for the teacher

Багшийн зааж буй арга барил сайн хангалттай гэж 54.5 хувь нь, зааж буй байдал 86.4 хувь нь сайн гэж үнэлжээ.

3. Биологийн хичээлийн хөтөлбөрийн үнэлгээ

Биологийн хичээлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх орчин нөхцөл, сургалтын хэрэглэгдэхүүний

нөөц бололцооны талаар асуухад 40.7 хувь нь дунд зэрэг, 33.3 хувь нь сайн, 13.8 хувь нь маш сайн гэж хариулсан. 12.2 хувь нь муу гэж сэтгэл дундуур хариулсан нь биологийн кабинетэд ордоггүй, хичээл цахим-танхим хослож орж байсантай холбоотой болов уу (Зураг 11).




Figure 11. Curriculum implementation environment and resources

Биологийн хичээлийн хөтөлбөрийг 2020-2021 оны хичээлийн жилд цахимаар судласнаар оюутанд бие даан ажиллах чадварыг 36.3 хувь нь сайн, 13.6 хувь нь маш сайн, бичих ур чадварыг 36.3 хувь нь маш сайн, ярианы ур чадварыг 31.8 хувь нь дунд зэрэг, 22.7 хувь нь сайн, мэргэжлийн мэдлэг 27.3 хувь нь сайн, харилцааны ур чадвар

27.3 хувь нь сайн, 18.2 хувь нь маш сайн гэж хариулсан байхад 2021-2022 оны жилд цахим-танхимаар судласнаар оюутанд бие даан ажиллах чадварыг 42.3 хувь нь, бичих ур чадварыг 37.4 хувь нь, ярианы ур чадварыг 4.9 хувь нь, мэргэжлийн мэдлэг 11.4 хувь нь олгодог гэж хариулсан (Зураг 12).




Figure 12. Provision of program content

2020-2021 оны хичээлийн жилд Биологийн хичээлийг 100 хувь цахим хэлбэрээр ороход хөтөлбөрийн давуу, сул талыг тодорхойлно уу

гэсэн асуултад хариулахдаа дараах байдлаар хариулжээ.

Давуу тал	Сул тал
Багшийн мэдлэг, ур чадвар- 68.1 хувь	Анги, танхим, тоног төхөөрөмж- 59 хувь
Бусад хөтөлбөрөөс суралцах боломж- 54.5 хувь	Цахим сургалт-63.6 хувь
Суралцагчтай тулж ажиллах- 45.4 хувь	
Багаар ажиллах боломж-27.2 хувь	
Бие даан хөгжих чадвар - 68.1 хувь	




Figure 13. Advantages and disadvantages of the delivery of the biology curriculum

2021-2022 оны хичээлийн жилд Биологийн хичээлийн хөтөлбөрийг 50% цахим- 50% танхим

хэлбэрээр хослон орохын давуу, сул талыг дараах байдлаар үнэлжээ.

Давуу тал	Сул тал
Багшийн мэдлэг, ур чадвар (11.5%)	Анги танхим, тоног төхөөрөмж (20.6%)
Цахим хэлбэрийн сургалт (9%)	Бусад хөтөлбөрөөс суралцах боломж (7.5%)
Танхим-Цахим хэлбэрийн сургалт (30.3%)	Суралцагчтай тулж ажиллах (28.3%)
Бие даан хөгжих чадвар (26.2%)	Багаар ажиллах боломж (9.2%)




Figure 14. Advantages of combined online and classroom learning in Biology curriculum 2021-2022




Figure 15. Strengths and weaknesses in the provision of biology curriculum content in 2021-2022

Хэлцэмж

Олон улсын их дээд сургуулиудад оюутны сэтгэл ханамжийн судалгаа /ОСХС/-г Анх АНУ гэхэд 1650 онд оюутнууд сайн дураараа сургуулийнхаа боловсролын үйлчилгээг үнэлэх ажлын эхлүүлсэн ба 1960 онд ихэнх дээд сургуулиуд системтэйгээр сэтгэл ханамжийн судалгааг зохион байгуулдаг болжээ [15]. Тиймээс оюутны сэтгэл ханамжийн судалгаа (ОСХС) гэдэг нь оюутны боловсрол авахад зориулж байгаа боловсролын чанар, сургуулийн зүгээс өгч байгаа үйлчилгээнүүд (номын сан, багш, сурах орчин, мэдээллийн технологийн асуудал)-д өгөх ерөнхий сэтгэл ханамжийг илрүүлэхэд зориулагддаг байна.

Аливаа хэрэглэгч нь авч байгаа үйлчилгээндээ сэтгэл хангалуун байх нь олон хүчин зүйлээс хамаарна. Энэ талаар судалгааны олон төрлийн загварууд байх бөгөөд SERVQUAL загвар (Parasuraman, 1985), SERVPERF (Cronin and Taylor, 1992), NETQMEX (Ho and Wearn, 1996), HEdPPERF (Abdullah, 2006) загварууд байдаг байна [5].

Судлаач A.Parasuraman (1985) үйлчилгээний чанар хэрэглэгчийн сэтгэл ханамжаар тодорхойлогдоно хэмээн үзэж энэхүү үзэл санааг хөгжүүлж, үйлчлүүлэгчийн хүлээгдэж буй үр дүн, бодит үнэлгээний зөрүүгээр үйлчилгээний чанарыг тодорхойлж болно гэжээ [16].

Канадын их дээд сургуулийн боловсролын үйлчилгээг оюутны сэтгэл ханамжаар үнэлэхдээ: оюутнуудын хамгийн өндөр сэтгэл

ханамж, судалгаа хийх нөхцөл боломж, багшийн хичээл заалт болон сургалтын чанар гэх мэт үзүүлэлтээр эрэмбэлэн жил бүр олон нийтэд мэдээлдэг. Энэ нь сургуулиудын хооронд бодит өрсөлдөөн бий болно гэж үздэг байна [14].

Beaumont (2012) HEdPERF загвар дээр үндэслэн дээд боловсролын чанарыг 6 фактор, фактор бүр нь 4 асуулгатай, 1-10 оноогоор үнэлэх нэгэн загварыг боловсруулсан байна. Үүнд:

1. Сургалт - Лекцийн чанар, Семинар/ лабораторийн чанар, Багшийн заах арга зүй, Хичээлийн агуулгын ач холбогдол
2. Багш - Мэргэжлийн мэдлэг, туршлага: Оюутныг дэмжиж, туслах байдал, Оюутны хэрэгцээг ойлгох байдал, Сургалтанд оюутны анхаарлыг татах чадвар, Харилцааны чадвар
3. Сургалтын зохион байгуулалт, материаллаг байдал - Сургалтын зохион байгуулалт, менежмент, Сургалтын уян хатан байдал, Сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн чанар, хүртээмж
4. Захиргааны ажилтан – Тэдний мэдлэг чадвар, Оюутныг дэмжиж туслах байдал, Оюутны хэрэгцээг ойлгох байдал, Асуудлыг шуурхай шийдвэрлэлт
5. Оюутны хөгжил – Нийгмийн үйлчилгээ, Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээ, Санхүүгийн дэмжлэг, Бусад төрлийн үйлчилгээ

6. Бусад – Хичээлийн байр ба түүний байршил, Хичээлийн анги, танхимын нөхцөл, их сургуулийн нэр хүнд, оюутны санал хүсэлт сонсох, эргэж мэдээлэх тогтолцоо зэрэг [9, 10, 12] чиглэлээр ОСХС-г үнэлж байна.

Манай улсад сүүлийн жилүүлдэд Дээд боловсролын байгууллагын сургалтын чанарын асуудал хурцаар тавигдаж багш бүр өөрийн сургах зүйн чанарт анхаарах хандлагатай болсон.

Р.Чанцалдулам 2010 онд “Хөтөлбөрийн чанарын менежмент: оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа” илтгэлдээ төгсөгч, суралцагчийн сэтгэл ханамж нь дээд боловсролын байгууллагын чанарын хэмжүүр юм. Энэ нь оролцогч талуудын сэтгэл ханамжийн түвшин байдаг. ХААИС-ийн төгсөгчийн сэтгэл ханамжийг тодорхойлохдоо: Сургуулийн имидж, үйлчилгээний чанар, итгэл найдвар, үнэ цэнэ, сэтгэл ханамж, үнэнч байдал зэрэг үзүүлэлтээр үнэлж хөтөлбөрөөр төгсөгчийн сэтгэл ханамж, сургуулийн имидж, сургуулийн үнэ цэн нь хүчтэй нөлөөлж байгааг тодруулсан байна [8].

Ч.Долгоржав, Б.Батчулуун нар 2015 онд “МУБИС-ийн оюутны сэтгэл ханамжийн судалгааг шинжлэх нь” сэдэвт өгүүлэлдээ Тухайн хичээл оюутны хэрэгцээ, сонирхолд нийцдэг тухай, багшийн харилцааны соёл, хичээлийн цаг ашиглалт, бодит үнэлдэг тухай, багш оюутанд тусалдаг тухай, хичээлийг заах ур чадвар гэсэн үзүүлэлтээр ОСХС-г явуулж боловсролын үйлчилгээний чанарт бус багшийн үйл ажиллагаанд төвлөрдөг нь дутагдалтай байна. Цаашид олон төрлийн үнэлгээг хэрэглэх санал дэвшүүлсэн байна [3].

Т.Сарантуяа 2017 онд “Оюутны сэтгэл ханамжийн судалгаа” илтгэлдээ КТМС-ийн сургалтын албанаас улирал бүр багшийн чадавхи, сургалтын материаллаг баазтай холбоотой Хичээлийн агуулга стандартад тохирч буй байдал, багшийн заах арга барил, багшийн хичээлийн цагийг үр дүнтэй ашиглаж буй байдал, багш суралцагчдын харилцаа, нөөц материал бүрдүүлэлт зэрэг үзүүлэлтээр 1-5 оноогоор үнэлэн сэтгэл ханамжийн судалгааг тухайн хичээлд суурилж хийсэн байна [6].

2020 оны байдлаар М.Итгэл “МУИС-ийн оюутны сэтгэл ханамжийн судалгааны шинжилгээ” сэдэвт өгүүлэлдээ: Одоогийн байдлаар МУИС-ийн суралцагчдаас сэтгэл ханамжийн судалгааг тухайн хичээлд суурилж байна. Энэхүү судалгааны ажлын хүрээнд

Beaumont нарын боловсруулсан HEdPERF загвар дээр тулгуурлан МУИС-ийн оюутны сэтгэл ханамжийг судлах хэмжилтийн загварыг боловсруулж хэмжилтийн найдвартай байдлыг шинжилж нийцэл нь сайнбайгаа нь найдварын зэрэг өндөр байна гэж үзсэн байна [5].

Эндээс үндэслэн бидний судалгаа нь тухайн хичээл болох биологийн хичээлийн сургалтын чанарыг дээшлүүлэхдээ: Багшийн заах арга зүйг дээшлүүлэх, багшийн мэдлэг ур чадварыг тасралтгүй хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг сайн зохион байгуулах, багш оюутныг дэмжих хөтөлбөр боловсруулж сайжруулах зэрэг үзүүлэлтээр судалгааг явуулсан. Ингэхдээ Beaumont (2012) HEdPERF загвар дээр үндэслэн:

1. Сургалт - Лекцийн чанар, Семинар/ лабораторийн чанар, Багшийн заах арга зүй, Хичээлийн агуулгын ач холбогдол
2. Багш - Мэргэжлийн мэдлэг, туршлага: Оюутныг дэмжиж, туслах байдал, Оюутны хэрэгцээг ойлгох байдал, Сургалтанд оюутны анхаарлыг татах чадвар, Харилцааны чадвар
3. Сургалтын зохион байгуулалт, материаллаг байдал - Сургалтын зохион байгуулалт, Сургалтын уян хатан байдал, Сургалтын хэрэглэгдэхүүн, техник хэрэгслийн чанар, хүртээмж зэрэг чиглэлийн дагуу асуумж боловсруулан 1-5 оноогоор үнэлж дүгнэсэн.

Дүгнэлт:

“Ач” АУИС-ийг 2020-2022 онд 1 дүгээр курсэд Биологи хичээлийг судласан оюутны төлөөлөл болох 147 оюутнаас авсан сэтгэл ханамжийн судалгааны үр дүнгээс харахад биологийн хичээлийн сургалтын үйл явц 84.8 хувь буюу сайн явагдаж байна гэж үнэлж сэтгэл ханамж өндөр байна. Үүнд:

1. Биологийн хичээлийн сургалтын үйл ажиллагаа нь 2020-2021 оны хичээлийн жилд 100 хувь цахим, 2021-2022 оны хичээлийн жилд 50 хувь цахим-танхим хослосон сургалтаар судалсан хичээлийн агуулгыг шинжлэх ухааны нэгдмэл байдлаар тулгуур зүй тогтолд үндэслэн юмс үзэгдлийг өргөн хүрээгээр, жишээ баримтаар тайлбарлан явуулсан гэж оюутнууд дүгнэжээ.
2. Хөтөлбөрийн агуулгыг харьцуулж дүгнэн мэдлэг, чадварыг хамтад нь олгодог, хичээл хоорондын уялдааг өмнөх хичээл

болон дараагийн хичээлтэй уялдуулан заадаг гэж хариулжээ.

3. Цаашид хичээлийн чанар, үр дүнг дээшлүүлж, оюутан нэг бүрийн дадлагажилтыг сайжруулахын тулд лекц семинарын, агуулгын харьцааг зохистой болгох чиглэлээр зарим өөрчлөлт хийх, дадлагын хичээлийг тогтмол танхимаар, харилцан ярилцаж орох шаардлагатай гэж дүгнэлээ.
4. Семинарын хичээл, дадлага хийлгэх сургалтын орчин (анги танхим, тоног төхөөрөмж) нөхцлийг орчин цагийн зохих шаардлагад хүртэл нийцүүлж тохижуулах шаардлагатай гэж үзэж байна.
5. Сургалтыг цахим хэлбэрээр орох давуу тал нь бие даан ажиллах чадвар, бичих ур чадвар илүү хөгжсөн бол Цахим-Танхим хослосон хэлбэрээр орох нь бие даан хөгжих, суралцагчтай тулж ажиллах, харилцан ярилцах, санал бодлоо илэрхийлэх чадвар давуу тал болж байна. Цахим хэлбэрээр ороход багаар ажиллах чадвар, хэл ярианы хөгжлийн чадвар муу хөгжиж байгааг цаашид анхаарах шаардлагатай гэж үзлээ.

Талархал

“Ач” АУИС-ийн 2021, 2022 онд биологи хичээлийн хөтөлбөр судалсан судалгаанд идэвхитэй оролцсон оюутнууддаа, энэхүү судалгааг бичихэд зөвлөгөө өгсөн профессор багш нартаа талархал илэрхийлье.

Ном зүй

1. “Ач” Анагаах Ухааны Их Сургууль, (2021). “АЧ” АУИС-д баримтлах дүрэм журмын эмхэтгэл (2015-2021). Улаанбаатар х.51-56
2. “Ач” Анагаах Ухааны Их Сургууль, (2021). “АЧ” АУИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн үйл ажиллагааны тайлан, цаашдын зорилт. Улаанбаатар.
3. Долгоржав Ч., Батчулуун Б. (2015). МУБИС-ийн оюутны сэтгэл ханамжийн судалгааг шинжлэх нь. Залуу судлаач эрдэм шинжилгээний бичиг. Улаанбаатар. х.188-194
4. Жадамба Б., Чимэдлхам Ц. (2001). Судалгааны арга зүй. Улаанбаатар
5. Итгэл М. (2022). МУИС-ийн оюутны сэтгэл ханамжийн судалгааны шинжилгээ. Улаанбаатар. х.3-9
6. Сарантуяа Т. (2017). Оюутны сэтгэл ханамжийн судалгаа. Улаанбаатар
7. Түмэндэмбэрэл Д., Гита Штейнер Хамси (2009). Хяналт-Шинжилгээ үнэлгээ хийх аргазүй. Улаанбаатар. х.15-20
8. ХААИС. Чанцалдулам Р.(2014). Хөтөлбөрийн чанарын менежмент: Оролцогч талуудын сэтгэл ханамжийн судалгаа. Улаанбаатар. х.20-29
9. Abdullah, F. (2005). HEdPERF vs. SERVPERF: The quest for ideal measuring Instrument of Service Quality in Higher Education Sector. Qual. Assur., Vol. 13(4), pp.305-328
10. Abdullah, F. (2006). The development of HEdPERF: A new measuring instrument of service quality for the higher education sector. International Journal of Consumer Studies, Vol 30(6), pp.569-581
11. Abdullah, F. (2006). Measuring service quality in higher education: three instruments compared. International Journal of Research & Method in Education Vol.29, No.1, pp.71-89
12. Beaumont, D.J. (2012). Service Quality in Higher Education: Students' viewpoint, Manchester: university of Manchester
13. Glenn, Erickson., (2013). A Survey of Faculty Development Practices. University of Nebraska-Lincoln.
14. John, A. Centra. (2013). How Universities Evaluate Faculty Performance: A Survey of Department Heads.
15. Lion, F. Gardiner. (2013). Faculty Development in Higher Education, The National Academy.
16. Parasuraman. A, Valarie. A, Zeithaml & Berry, L. L. (1988)., SERVQUAL: a multiple-item scale for measuring consumer perceptions of service quality. Journal of Retailing 64(1): pp.12-37

*Танилцаж нийтлэх санал өгсөн:
Анагаах ухааны доктор, профессор
Д.Отгонбаяр*